



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН АЛБАН ДААЛГАВАР

2026 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай

Улсын хэмжээнд 2025 онд 15 аймгийн 84 сум, нийслэлийн 3 дүүрэгт, нийт 273 удаагийн ой, хээрийн гал түймэр бүртгэгдсэн нь 2024 онтой харьцуулахад 2 дахин өссөн байна.

Дээрх ой, хээрийн гал түймэрт урьдчилсан байдлаар ойн 77,250 га, хээрийн 870,453 га, нийт 947,703 га талбай өртсөн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт гал түймэрт өртсөн талбай 9,1% буурч, урьдчилсан байдлаар ой, хээрийн гал түймрийн улмаас 370 тэрбум орчим төгрөгийн хохирол учирсан байна.

Унтраах ажиллагаанд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид, орон нутгийн мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн нийт 13,256 хүн, 2002 автомашинтай ажиллаж, Зэвсэгт хүчин болон Онцгой байдлын байгууллагын нисдэг тэргээр нийт 55 удаагийн нислэг үйлдсэн.

2025 онд бүртгэгдсэн ой, хээрийн гал түймрийн 63,5%-ийг иргэдээс өгсөн дуудлага, мэдээллээр, 32,9%-ийг сансраас гал түймрийн дулааны цэг илрүүлэх сайтуудаар, 3,6%-ийг нисдэг тэргээр тандалт хийн илрүүлж, шуурхай хариу арга хэмжээг авч ажиллалаа.

Улсын онцгой комиссын даргын баталсан 2025 оны 01 дүгээр тушаал, удирдамжийн хүрээнд хуурайшилтын улиралд түймрийн эрсдэлтэй бүс нутагт байнгын болон хөдөлгөөнт хяналтын цэг ажиллуулж, гарсан гал түймрийг хохирол багатай, шуурхай унтраах ажиллагааг зохион байгуулснаар ой, хээрийн гал түймэрт өртсөн талбай, учирсан хохирол 9,1 хувиар буурсан байна.

Цаг уур, орчны шинжилгээний газраас ирүүлсэн 2026 оны 1 дүгээр улирлын цаг агаарын урьдчилсан мэдээллээр агаарын температур нийт нутгаар олон жилийн дунджаас 2 дугаар сард хүйтэн, 3 дугаар сард дулаан, 4 дүгээр сард дундаж байх ба хаврын улиралд цаг агаарын огцом дулаарал, хүйтрэл үе үе ажиглагдах, агаарын температур ихэнх нутгаар дундаж, хур тунадас нийт нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байгаа буюу хуурайшилт их байж, салхи шуурга ихтэй байх магадлал өндөр байна.

Иймд ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх, гал түймэр унтраах ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, иргэн, хуулийн этгээдийн хамтын

ажиллагааг сайжруулах, ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор ДААЛГАХ НЬ:

Нэг. Батлан хамгаалахын сайд,
Улсын онцгой комиссын орлогч Д.Батлутаг:

1.1. Тусгай чиг үүргийн нислэг үйлдэх нисдэг тэрэгний техникийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, хүн хүч, техник хэрэгсэл очих боломжгүй алслагдсан ой, хээрийн бүсэд гарсан гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд нисдэг тэргээр ой, хээрийн гал түймрийн голомтод бие бүрэлдэхүүнийг шуурхай хүргэх ажиллагааг зохион байгуулахыг,

1.2. Тусгай чиг үүргийн нислэг үйлдэх нисдэг тэрэгний нисгэгчдэд Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, бусад дүрэм, журмын сургалтыг зохион байгуулж, нислэгийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг тогтмол өгч байхыг,

1.3. Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудыг шаардлагатай техник, багаж хэрэгслээр ханган, бэлтгэл бэлэн байдлыг хангуулж, бие бүрэлдэхүүнд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Онцгой байдлын байгууллагатай хамтран сургалт, дадлага зохион байгуулахыг,

1.4. Ой, хээрийн гал түймрийн голомтод ажиллаж байгаа Онцгой байдлын байгууллагын алба хаагчид болон мэргэжлийн алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн ажилтан, алба хаагчдыг зэрлэг ан амьтнаас хамгаалах зорилгоор зэрлэг ан амьтан үргээх дуу гаргах хэрэгсэл болон галт хэрэгсэл бүхий алба хаагчийг голомтын бүсэд томилон ажиллуулахыг.

1.5. Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар байгууллагын орчим гарсан ой, хээрийн гал түймрийн мэдээллийг Онцгой байдлын байгууллагад шуурхай мэдээлэх, цаг алдалгүй унтраах арга хэмжээг зохион байгуулахыг.

Хоёр. Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын орлогч дарга,
хошууч генерал Г.Ариунбуянд:

2.1. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, түймэр унтраах дадлага сургалтыг аймаг, нийслэлийн төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэдийн оролцоотой зохион байгуулахыг,

2.2. Төв, орон нутгийн хэмжээнд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, унтраах ажиллагааг зохион байгуулахад төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага болон хуулийн этгээд, иргэдийн оролцоог уялдуулан зохицуулах, тэдгээрт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэхийг,

2.3. Онцгой байдлын байгууллагын ой, хээрийн гал түймэртэй тэмцэх автомашин, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулахыг,

2.4. Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаа, сургалт дадлагын үед алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангуулж, хөдөлмөрийн аюулгүй

байдал, эрүүл ахуйн тухай хууль бусад холбогдон гарсан дүрэм, журмыг судлуулан, ажиллагааны өмнө тогтмол зааварчилгаа өгч байхыг,

2.5. Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн үед Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар бүлгийн 29 дүгээр зүйлийн 29.1.7-д заасныг хэрэгжүүлэн, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хүч хэрэгслийг дайчлан оролцуулах, тэдгээрийг мэргэжлийн удирдлагаар хангахыг,

2.6. Ой, хээрийн гал түймрийн голомтод олон хоног, удаан хугацаагаар ажилласан үед алба хаагчдад эм, эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнс, өдөр тутмын болон хамгаалах тусгай хувцасны эдэлгээний хугацааг харгалзахгүй нөхөн хангалт хийх, нөөц бүрдүүлэхийг,

2.7 Ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй бүс нутагт, Ойн тухай хуулийн 3.1.17-д заасан хугацаанд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, түймэр унтраах зорилгоор шуурхай хөдөлгөөнт бүлэг ажиллуулахыг.

2.8. Ой, хээрийн гал түймэр унтраах, урьдчилан сэргийлэх ажиллагаанд олон улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын дэвшилтэд техник, технологийг судалж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг,

2.9. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, унтраах ажлыг нэгдсэн удирдлага, бодлого, зохион байгуулалтаар хангах, гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэхийг.

Гурав. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Батбаатарт:

3.1. Ой, хээрийн гал түймэр гарах эрсдэл өндөртэй аймаг, нийслэл, сум, дүүрэгт Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан, ой, хээрийн гал түймэр унтраах техник багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэн ажиллахыг,

3.2. Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн сансрын хиймэл дагуулын мэдээллээр авсан цаг агаарын болон ой, хээрийн гал түймрийн голомт, тархалтын зураг, хуурайшилтын мэдээг тухай бүрд /баяр, амралтын өдрүүдэд/ шуурхай боловсруулж, Онцгой байдлын байгууллагад хүргүүлэхийг,

3.3. Ойн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.13-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрийн аюултай үед ой, хээрийн гал түймрээс сэрэмжлүүлэх, орон нутагт эргүүл, хяналтын цэг ажиллуулах болон энэ ажилд бүх нийтийг татан оролцуулах талаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахыг,

3.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 153 дугаар зарлигийн 1.4-т заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй бүс нутагт гал түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын нислэг үйлдэх зардлыг төсөвт тусгаж, Зэвсэгт хүчин болон Онцгой байдлын байгууллагатай хамтран нислэг үйлдэхийг,

3.5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 153 дугаар зарлигийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2.15-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, аюул тулгарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зохион байгуулалтын талаар олон нийтийг мэдээлэл, заавар, зөвлөмжөөр хангах, нэвтрүүлэг бэлтгэх, сургалт сурталчилгаа зохион байгуулахыг,

3.6. Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 106 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, ой хээрийн гал түймрээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажлыг хууль хяналтын байгууллага, сумдын ойн анги, нөхөрлөлийн хүмүүсийг оролцуулан шуурхай зохион байгуулахыг,

3.7. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, сумны нөөцийг бүрдүүлэх, тэдгээрийн аюулгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, шаардлагатай үед шуурхай экспедицийг ажиллуулах бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг,

3.8. Ойн тухай хуульд заасан түймрийн аюултай үед ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалт баялгийг ашиглах, аялал зугаалгаар явах үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хязгаарлах, хориглох, холбогдох төрийн болон хууль хяналтын байгууллагуудтай хамтран хяналтын байнгын болон хөдөлгөөнт цэг байгуулж, хууль, дүрэм, журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд авсан арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлэхийг,

3.9. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор ойн арчилгаа, унанги модны цэвэрлэгээний ажлыг эрчимжүүлж, түймрээс хамгаалах шороон болон халз зурвасыг сэргээх, шинээр нэмж байгуулах ажлыг зохион байгуулахыг,

3.10. Ойн сан бүхий газарт гал түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэх талаар Ойн тухай хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийг Зөрчлийн тухай хуульд зааснаар арга хэмжээ авч, улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч нарын ажлыг эрчимжүүлж ажиллахыг,

3.11. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт заасан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэхийг,

3.12. Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасныг зөрчиж ойн сан бүхий газарт гал түймэртэй тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх талаар хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй хүн, хуулийн этгээдэд хариуцлага тооцохыг,

3.13. Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 10 дахь хэсэгт заасныг зөрчиж ойн тухай хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлээгүй хүн, хуулийн этгээдэд хариуцлага тооцохыг,

3.14. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг хариуцан үйл ажиллагаа явуулж буй байгаль хамгаалагчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангуулах, ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, түймрээс хамгаалах, унтраах ажиллагааг шуурхай зохион байгуулахыг,

3.15. Улсын Тусгай хамгаалалттай газар нутагт гарсан ой, хээрийн гал түймрийг унтраахаар ажиллаж буй мэргэжлийн байгууллагын алба хаагчид болон мэргэжлийн албад, сайн дурын хэсгийн ажилтан нарт шаардлагатай шатах тослох материал, шатахуун, хоол хүнс, багаж хэрэгсэл, туулах чадвар сайтай автомашинаар хангахыг.

Дөрөв. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн, М.Бадамсүрэнд:

4.1. Ойн тухай хуулийн 3.1.17-д заасан ой, хээрийн гал түймрийн аюултай үед ургац тариалалт, хураалтын үйл ажиллагааны өмнө тариалан эрхлэгч, иргэн, аж ахуй нэгжид мэргэжлийн байгууллагатай хамтран ой, хээрийн гал түймрээс

урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний чиглэлээр дадлага, сургалт зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг,

4.2. Ой, хээрийн гал түймэр гарсан үед түймэр унтраах ажиллагаанд мал аж ахуй, тариалан эрхлэгчдийн тусгай зориулалтын автомашин, техник, чирэгч механизмаар дэмжлэг үзүүлж ажиллахыг,

4.3. Монгол орны бэлчээр, газар тариалан, ой, таримал ургамлыг ой, хээрийн гал түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, зурвас татах, ургамал хамгааллын чиглэлээр тусгай хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхийг,

4.4. Ой, хээрийн гал түймрийн голомтод удаан хугацаагаар үүрэг гүйцэтгэж буй төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид, сайн дураар болон дайчлагдан ажиллаж буй иргэдийн хоол хүнсний аюулгүй байдалд хяналт тавьж, чанарын шаардлага, илчлэг тэжээллэгтэй хоол хүнсээр хангах, нөөц бүрдүүлэхийг.

Тав. Эрүүл мэндийн сайд
Улсын онцгой комиссын гишүүн, Ж.Чинбүрэнд:

5.1. Гамшиг осол, гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээг тухайн нутаг дэвсгэрт үзүүлэх, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулахыг,

5.2. Ой, хээрийн гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх, нэмэлтээр дайчлан ажиллах аймаг, нийслэл, сум дүүргийн мэргэжлийн албад, мэргэжлийн анги, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн ажилтан, алба хаагчдад хачигт халдвараас урьдчилан сэргийлэх, дархлаажуулах тарилгад хамруулах, тарилгын нөөц бүрдүүлэхийг,

5.3. Ой, хээрийн гал түймрийн голомтод удаан хугацаагаар /10 хоногоос дээш/ үүрэг гүйцэтгэж буй төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид болон дайчлагдсан иргэд, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг, төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, алба хаагчдад эрүүл мэнд, сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилгоор эмнэлгийн хөдөлгөөнт баг томилон ажиллуулах, эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материалын нөөц бүрдүүлэхийг.

Зургаа. Боловсролын сайд
П.Наранбаатарт:

6.1. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах анхан шатны мэдлэг олгох сургалт, сурталчилгааг мэргэжлийн байгууллагатай хамтран бүх шатны боловсролын байгууллагын багш, ажилчдад зохион байгуулахыг,

6.2. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах анхан шатны мэдлэг олгох сургалт, сурталчилгааг мэргэжлийн байгууллагатай хамтран бүх шатны боловсролын байгууллагын оюутан, сурагчдад үе шаттайгаар зохион байгуулахыг,

6.3. Алслагдсан сум орон нутаг ой, хээрийн гал түймрийн эрсдэлтэй бүсэд үйл ажиллагаа явуулдаг боловсролын байгууллагын аюулгүй байдал, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах.

Долоо. Хил хамгаалах ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн,
бригадын генерал Ж.Бямбасүрэнд:

7.1. Хил орчмын ой, хээрийн гал түймэртэй тэмцэх чиглэлээр Онцгой байдлын байгууллагатай хамтран сургалт зохион байгуулж, бие бүрэлдэхүүнийг шаардагдах техник, багаж хэрэгслээр хангахыг,

7.2. Хил орчим гарсан ой, хээрийн гал түймрийн мэдээллийг Онцгой байдлын байгууллага, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд шуурхай мэдээлэх, цаг алдалгүй унтраах, арга хэмжээг зохион байгуулахыг,

7.3. Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд оролцож буй алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангуулж, сургалт дадлагыг тогтмол зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль бусад холбогдон гарсан дүрэм, журмыг судлуулсан, зааварчилгааг тогтмол өгч байхыг,

7.4. Хилийн бүс, хил орчмын нутаг дэвсгэр, хөрш зэргэлдээх орнуудын хил дамнан гарсан ой, хээрийн гал түймрийг унтраах, түймрийн тархалтыг таслан зогсоох, үйл ажиллагаа явуулах үед хоёр улсын томилгоот алба хаагч, иргэдийг хялбаршуулсан журмаар хил нэвтрүүлэх асуудлыг хоёр улсын Засгийн газар хоорондын байгуулсан хэлэлцээр бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг,

7.5. Түймрийн эрсдэл өндөр бүсэд байрлаж буй хилийн цэргийн анги, заставуудын алба хаагчдыг хамгаалах тусгай хувцас, багаж хэрэгслээр хангаж, ой, хээрийн гал түймэр унтраах дадлага сургалтыг Онцгой байдлын байгууллагатай хамтран зохион байгуулахыг,

7.6. Хил дамнан орж ирсэн болон хил давж гарсан ой, хээрийн гал түймрийн талаарх мэдээллийг тухай бүр Улсын онцгой комисс болон Онцгой байдлын байгууллагад албан бичгээр хүргүүлж баримтжуулахыг,

7.7. Хил орчмын бүсэд ой, хээрийн гал түймрээс хамгаалах шороон болон халз зурвас шинээр байгуулах, хуучин зурвасыг сэргээхийг,

7.8. Ой, хээрийн гал түймрийн голомтод ажиллаж байгаа Онцгой байдлын байгууллагын алба хаагчид болон мэргэжлийн алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн ажилтан, алба хаагчдыг зэрлэг ан амьтнаас хамгаалах зорилгоор зэрлэг ан амьтан үргээх дуу гаргах хэрэгсэл болон галт хэрэгсэл бүхий алба хаагчийг голомтын бүсэд томилон ажиллуулахыг.

Найм. Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн,
хошууч генерал Ж.Болдод:

8.1. Ойн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д заасныг хэрэгжүүлэн ой хээрийн гал түймрийн шалтгаан, эзэн холбогдогчийг тогтоох, энэ тухай холбогдох мэдээллийг улирал бүр Улсын онцгой комисс болон Онцгой байдлын ерөнхий газарт ирүүлэхийг,

8.2. Ойн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасныг хэрэгжүүлэн ой хээрийн гал түймрийн аюултай үед ойд зорчих иргэд, тээврийн хэрэгслийн

хөдөлгөөнийг хориглох, орон нутгийн төр захиргааны байгууллагатай хамтран байнгын болон хөдөлгөөнт хяналт, шалгалтын цэг ажиллуулахыг,

8.3. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/16, А/10 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан объектын болон ой, хээрийн гал түймрийн үед хамтран ажиллах журмыг хэрэгжүүлэх,

8.4. Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, Цагдаагийн ерөнхий газрын Экологийн Цагдаагийн албаны дарга нарын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдөр баталсан ой, хээрийн гал түймэртэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг,

8.5. Ой, хээрийн гал түймрийн талаарх мэдээ, мэдээллийг хүлээн авсан тухай бүр төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад мэдэгдэх, харилцан мэдээ, мэдээлэл шуурхай солилцохыг.

Ес. Аймаг, нийслэлийн Засаг дарга,
Онцгой комиссын дарга нарт:

9.1. Ойн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрийн цагийн байдлын тухай мэдээг Онцгой байдлын байгууллагад тухай бүр болон хагас, бүтэн жилээр гаргаж өгөхийг,

9.2. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалтыг хэрэгжүүлэн, нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэн ой, хээрийн гал түймэр унтраахад дайчлах гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг байгуулах, тэдгээрийг ой, хээрийн гал түймрийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох зорилгоор сургалт дадлагыг тогтмол зохион байгуулах, шаардагдах зардлыг шийдвэрлэхийг,

9.3. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д заасныг хэрэгжүүлэн нутаг дэвсгэртэй гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэхийг,

9.4. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй газарт түймэр тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор шороон болон халз зурвас шинээр байгуулах, сэргээх, шаардагдах төсөв, аймаг, сум, нийслэл, дүүргийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэхийг;

9.5. Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5-д заасныг хэрэгжүүлэн, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн ажилтнуудад хууль, эрх зүйн болон гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гарсан ой, хээрийн гал түймрийг шуурхай унтраах мэдлэг олгох, дадлагажуулах, ажилтнуудын бэлтгэл бэлэн байдлыг хангуулах сургалт дадлагыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагатай хамтран зохион байгуулж, шаардагдах зардлыг шийдвэрлэхийг,

9.6. Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.13-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймэр гарсан үед бүрэн эрхийнхээ хүрээнд хүн хүч, техник хэрэгслийг дайчлан, гарсан гал түймрийг унтраах ажлыг шуурхай зохион байгуулахыг,

9.7. Хариуцсан нутаг дэвсгэрт гарсан ой, хээрийн гал түймрийн голомтод ажиллаж буй мэргэжлийн байгууллага болон гал түймэртэй тэмцэх сайн дурын

хэсэг, мэргэжлийн ангийн ажилтан алба хаагчдыг шаардлагатай хоол хүнс, шатах тослох материал, автомашин, техник, багаж хэрэгслээр тасралтгүй хангах ажиллагааг зохион байгуулахыг,

9.8. Ойн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрээс учирсан хохирлыг хуулийн хугацаанд тогтоож, тайланд тусгахыг,

9.9. Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 1.7.1-д заасныг хэрэгжүүлж, ой, хээрийн гал түймрийн аюултай үед ой, хээрийн гал түймрийн эрсдэл их газар нутагт ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хөдөлгөөнт эргүүлийг байрлуулах, байнгын хяналтын цэг ажиллуулах, холбогдох зардлыг шийдвэрлэхийг,

9.10. Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад заасны дагуу сум, дүүргийн нутаг дэвсгэрт ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд зайлшгүй шаардлагатай багаж, хэрэгслийг бэлтгэх, бэлэн байдлыг хангуулж, нөөц бүрдүүлэхийг,

9.11. Ой, хээрийн гал түймэр унтраахад дайчлах гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн гишүүдэд ой, хээрийн гал түймэр унтраах сургалт, дадлагыг зохион байгуулахыг,

9.12. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний орон нутгийн хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах төсвийг батлуулан хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд хяналт тавихыг,

9.13. Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрч аймаг, нийслэлээс нэмэлт хүн хүч дайчлан ажиллах үед бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор харьяа эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагаас эрүүл мэндийн тусгай баг томилон ажиллуулахыг,

9.14. Бүх шатны Засаг дарга нар 03 дугаар сарын 20-оос 06 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 20-оос 11 дүгээр сарын 10-ны хооронд хуурайшилтын “аюултай”, “нэн аюултай” зэрэгт хүрсэн үед ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалдах нөөцийг ашиглах, аялал зугаалгаар явах болон бусад үйл ажиллагааг хязгаарлах захирамж гарган, хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг.

9.15. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшигтай тэмцэх чиглэлээр Онцгой байдлын байгууллагатай хамтран сургалт, дадлага ажлыг зохион байгуулахыг,

9.16. Хуурайшилтын улирал, түймрийн аюултай үед Гамшгаас хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасан хүч хэрэгсэл /Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэд/-ийг шаардлагатай тохиолдолд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын цэгт татан ажиллуулахыг,

9.17. Ойн санг гэрээгээр эзэмшигч байгууллагуудын түймрээс хамгаалах үйл ажиллагааг үнэлж, дүгнэхдээ хуулиар хүлээсэн эрх үүргийг зохих ёсоор биелүүлээгүй нөхөрлөл, аж ахуйн нэгжид хариуцлага тооцох, холбогдох тусгай зөвшөөрлийг цуцлах саналыг Байгаль орчны газраар уламжлуулан холбогдох албан тушаалтанд хүргүүлж шийдвэрлүүлэхийг.

Албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, мэдээ тайланг Улсын онцгой комиссын ажлын албанд 06 дугаар сарын 08, 11 дүгээр сарын 09-ний өдрийн дотор тус тус ирүүлэхийг холбогдох комиссын гишүүд, дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Х.ГАНХУЯГ